

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БАТЛАВ

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙХ ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХҮРЭЭНД УЛСЫН, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БАРИГДСАН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ЗУРАГ ТӨСӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮЖИЛТИЙГ ХЯНАЖ,
ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 02 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛГО: Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх гүйцэтгэл, нийцлийн аудитын хүрээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан зарим зам, барилгын ажлын зураг төсөл, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэх, олгосон санхүүжилт нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Эхлэх хугацаа: 2025 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дуусах хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр

Байршил: Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

“Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт нийцэл, гүйцэтгэлийн аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ. Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу мэргэжлийн тусгай мэдлэг, ур чадвар бүхий этгээдийг шинжээчээр аудитад татан оролцуулна.

ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, барилга байгууламж, авто зам, зураг төсөл, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэх, санхүүжилт, гүйцэтгэлийг хянаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

... 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр хийж гүйцэтгэнэ. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Барилга, байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах;	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйл "Барилга байгууламжийн төсөв", 25 дугаар зүйл "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх", 38 дугаар зүйл "Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг", 39 дүгээр зүйл. "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт", Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНБД 81-95-12*/2020/, холбогдох бусад норм, дүрэм, стандарт	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа зарим барилга, байгууламжийн төсөвт өртөг нь үр ашиг, арвилан хэмнэлттэй байж, Монгол Улсын хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын шаардлагад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргахад оршино.	<ul style="list-style-type: none"> ✓ Техникийн нөхцөл, бусад зөвшөөрлийг хууль журмын хүрээнд авсан байх; ✓ Зураг төслийг холбогдох тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, хуулийн этгээд боловсруулсан байх; ✓ Зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргасан байх; ✓ ТЭЗҮ, эскиз, ажлын зураг нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан байх; ✓ Төсвийг батлагдсан зургийг үндэслэн, гүйцэтгэсэн байх, ✓ Төсвийг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон байх,
2	Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад барилгын материалын орц, тоо хэмжээ, нэр төрлийг хянаж, батлагдсан төсөв болон олгосон гүйцэтгэлийн хооронд тоо хэмжээний зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах;	Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйл "Барилга байгууламжийн төсөв", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНБД 81-95-12*/2020/, холбогдох бусад хууль, журам, заавар, норм, дүрэм.		<ul style="list-style-type: none"> ✓ Олгосон санхүүжилт нь гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, төсөвт өртөгтэй нийцэж байх. ✓ Магадалшгүй ажлын зардал, бусад зардалд хэтрэлт, хэмнэлт гарсныг гүйцэтгэлийн санхүүжилтэд бүрэн, үнэн зөв тусгасан байх;
Нэмэлт шаардлага. /Тухайн ажил үүргийн хүрээнд нэмэлт ажил хийгдэх тохиолдолд нөхөж оруулна.				
3				

- Шинжээчийн үе шатны ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зай "single" үсгийн хэмжээ Arial 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Шинжээчийн дүгнэлт гаргах үндэслэл болгосон холбогдох нотлох баримт, тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль, стандарт, норм, дүрэм зэрэг шалгуур болгосон мэдээллийн эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажилбаруудыг төсөл, арга хэмжээ бүрээр, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гарсан үр дүн, үр нөлөөг тусгасан мэргэжлийн дүгнэлт бүхий тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн ажил гүйцэтгэх явцад барилга байгууламжийн зураг төсөл, гүйцэтгэлийн санхүүжилтэд илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтээс гадна илэрсэн зөрчлийг арилгах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх боломжийн талаар зөвлөмж, санал боловсруулж, тайланд тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох баримт, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий, төслийн эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, барилга, байгууламжийн зураг төсөл, магадлалын чиглэлээр дүгнэлт гаргаж байсан, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага туршлагатай, иргэн, хуулийн этгээд /түншлэл/ байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь тухайн ТАХ-нд захиалагчийн хяналт болон санхүүжилт олгож буй байгууллагатай сүүлийн 2 жилийн хугацаанд ажиллаагүй байх.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Нийслэл дэх Төрийн аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Дараах шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээд /түншлэлээр оролцох/-тэй хамтран ажиллах бөгөөд зөвлөх үйлчилгээг багаар үзүүлнэ. Үүнд:

- Багийн ахлагч:

Барилгын инженер, Монгол Улсын Тэргүүлэх төсөвчин, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 12 ба түүнээс дээш жил ажилласан байх;

- Багийн гишүүд:

Барилгын мэргэшсэн инженер, халаалт, агаар сэлгэлт, цахилгаан, холбоо, ус хангамж, аривтгах татвургын инженер, мэргэшсэн төсөвчин, мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан хуулийн этгээд, шинжээчид нь ажил эхлэхийн өмнө болон аудитын явцад захиалагч тал /Аудитын баг/-тай уулзалт, ярилцлага хийж, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Аудитын багт долоо хоног тутамд ажлын явц, гүйцэтгэлийг танилцуулна.

Аудитын явцад үүссэн шийдвэрлэх боломжгүй аливаа асуудлыг тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ.

Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө, танилцуулга), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);
- Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлнэ.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.